



**“МОНГОЛ ОРНЫ ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА”
сэдэвт үндэсний 5-р хурал**

2021 оны 03-р сарын 19, Улаанбаатар хот, Монгол улс

НОГООН БҮСИЙН ХУШИН ОЙН БАЙГАЛИЙН СЭРГЭН УРГАЛТЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

**Д.Цэндсүрэн, Б.Удвал, Н.Цагаанцоож, Г.Батсайхан, Д.Ганбат,
Б.Батчөдөр, Ц.Энхчимэг, А.Баяртулга, Э.Наранбаяр**

ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Ойн нөөц, ой хамгааллын салбар



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Food and Agriculture
Organization of the
United Nations



Хэрэглээний шинжлэх
ухаан, Инженерчлэлийн
сургууль



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН



**ХУРГАТАЙ
ХАЙРХАН**

Гэрээт ажил: УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БҮСИЙН ХУШИН ОЙН СУДАЛГАА

Захиалагч: Нийслэлийн Байгаль орчны газар

Санхүүжүүлэгч: Азийн сангийн “Хотын нөөц баялгийн тогтвортой менежментийг нэвтрүүлэх замаар Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөрийг нутагшуулах” төсөл

Гүйцэтгэгч: ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн
Ойн нөөц, ой хамгааллын салбар

Зорилго:

Улаанбаатар хотын ногоон бүс дэх хушин ойд явуулсан хушин ойн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох үндсэн зорилготой судалгааны ажлын хүрээнд хийгдсэн хушин ойн байгалийн сэргэн ургалтын явц, төлөв байдлыг үнэлсэн судалгааны үр дүнг танилцуулахыг зорилоо.



УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БҮСИЙН ХУШИН ОЙ

Улаанбаатар хотын ногоон бүсийн Ойн сангийн ойгоор бүрхэгдсэн нийт 95.2 мян.га талбайн **16520 га**-д хушин ой тархан ургаж (17.3%) байна. Улаанбаатар хотын ногоон бүсийн ой гарал үүслийн хувьд байгалийн аясаар сэргэн ургасан ой юм. Нийслэлийн ойн сангийн байгалийн ойн талбайг модны төрлөөр нь авч үзвэл ногоон бүсийн байгалийн ойн 18.22 хувийг хушин ой эзлэн ургаж байна (Улаанбаатар хотын ногоон бүсийн ой зохион байгуулалтын ажлын тайлан, 2016).

Дүүрэг	Ойн төрөл								Дүн
	Шинэс	Хуш	Нарс	Гацуур	Хус	Улиас	Улиангар	Бургас	
Баянзүрх	27713	11167	63	863	259	383		842	41290
Налайх	7374	178			349	1556	3	857	10317
Сүхбаатар	5782	3661	429	28	198		2		10100
Сонгино хайрхан	3916		9899		5710		25	3	19553
Хан-Уул	1509	1514	427	551	314			702	5017
Чингэлтэй	2999		497	41					3537
Багануур	833								833
Нийт дүн	50126	16520	11315	1483	6830	1939	30	2404	90647






МОНГОЛЫН АМЬСГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БҮСИЙН ХУШИН ОЙН ТАРХАЛТЫН ЗУРАГ

SENTINEL 2B ХИЙМЭЛЛ ДАГУУЛЫН 2020 ОНЫ 9-Р САРЫН 26-НЫ ЗУРАГ (Сувар УНХ - 3, 8, 4)






- **Судалгааны арга зүй**

Судалгааг дээж талбайн судалгааны аргаар явуулсан бөгөөд ойн моддын ташингын төлөв байдлын үнэлгээнд “Моддын төлөв байдлын зэрэглэл”-ийг (Цэндсүрэн, 2009), рекреацийн талхлагдлын түвшинг Ойн талхлагдлын зэргийг тодорхойлох шалгуурыг (Цэндсүрэн, 2009) үндэслэл болгов.

Байгалийн сэргэн ургалтын тооллогыг А.В.Побединскийн (1966) арга зүйн дагуу явуулсан бөгөөд байгалийн сэргэн ургалтын явцыг Ч.Дугаржавын (2006) үнэлгээний хэмнүүрийг үндэслэн үнэлсэн.



Хушин ойн таксацын үндсэн үзүүлэлтүүд

ДТ-н дугаар	Дээж талбайн нэр	Ойн бүрэлдэхүүн	Насны анги	Модны тоо (ш/га)	Өтгөрөл	Дундаж		Бонитет
						диаметр (см)	өндөр (м)	
ДТ-1	Дэндий	8Ш2Хш+Хс	IY	1680	0,7	16,7	20,2	IY
ДТ-2	Санзай	8Хш2Ш+ХсН	III	1020	0,6	23,8	24	II
ДТ-3	Жигжид	6Н3Хш1Хс+Ш	IY	1460	0,8	17,2	21,5	II
ДТ-4	Нүхт	7Хш3Н	IY	1160	0,7	28,0	24	II
ДТ-5	Түргэн	9Хш1Гц	IY	940	0,8	30.1	19.7	III
ДТ-6	Улиастай	5Хш5Ш	YII	800	0,5	23.0	22.0	IY
ДТ-7	Хандгайт	5Гц3Хш1Ш1Хс	IY	1940	0,7	20.4	18.3	IY
ДТ-8	Тэрэлж	9Хш1Ш	IY	1460	0.8	17.0	21.5	IY

Таксацын үндсэн үзүүлэлтүүдээс үзэхэд Улаанбаатар хотын ногоон бүсийн хамгийн хөгшин хушин ой Улиастайн аманд байгаа бөгөөд хамгийн залуу хушнууд Бага Баянд ургаж байна.

Ногоон бүсийн Санзай, Улиастай, Тэрэлж, Богдхан уулын Нүхт, Түргэний аманд хуш зонхилсон холимог бүрэлдэхүүнтэй хушин ой ургаж байгаа бол ногоон бүсийн Дэндий, Жигжид, Хандгайтад хуш бүхий шинэсэн ой, нарсан ой, гацууран ой ургаж байна.



ਸ੍ਰੀ ਗੁਰੂ ਗ੍ਰੰਥ ਸਾਹਿਬ ਜੀ



Ойн моддын төлөв байдлын үнэлгээгээр бүх мод нь **эрүүл ой байхгүй** байгаа бөгөөд ногоон бүсийн хушин ойн 60 гаруй хувь нь өсөлт саарч буй мододтой ой, 30 гаруй хувь нь өсөлт нь саарч доройтож буй мододтой ой байна гэж үнэлэгдлээ .



Ногоон бүсийн хушин ойн моддын дунджаар 64,6 хувь нь ямар нэг хэмжээгээр механик гэмтэл авсан, өсөлт нь саарч, титэм нь сийрэгжсэн, хатаж буй байдалтай байна.

➤ Хушин ойн байгалийн сэргэн ургалтын явц

Дээж талбай	Дээж талбайн нэр	Өсвөр моддын тоо, ш/га	Хушны өсвөр модны эзлэх хувь, %	Сэргэн ургалтын явцын үнэлгээ
ДТ-1	Дэндий	1760,0	70,4	Хангалтгүй
ДТ-2	Санзай	920,0	100,0	Муу
ДТ-3	Жигжид	1960,0	92,7	Хангалтгүй
ДТ-4	Нүхт	160,0	75,0	Муу
ДТ-5	Түргэн	40,0	-	Муу
ДТ-6	Улиастай	3220,0	93,8	Хангалттай
ДТ-7	Хандгайт	2500,0	100,0	Хангалтгүй
ДТ-8	Тэрэлж	1500,0	91,3	Муу

Судалгааны дүнгээс үзэхэд, рекреацийн талхлал ихтэй газруудад сэргэн ургалт муу байна. Өсвөр моддын тоонд хушны эзлэх хувь өндөр байгаа боловч тэдгээрийн өндөр 50 см-ээс доогуур, 50 см-ээс дээш өндөртэй нь гэмтсэн, цаашид ургах найдваргүй байдалтай байна.



Дүгнэлт

- Хушин ойн рекреацийн талхлал их байгаа нь байгалийн сэргэн ургалт муу, хангалтгүй явагдахад хүргэж байна.
- Ногоон бүсийн хушин ойд байгалийн сэргэн ургалт хангалтгүй явагдаж байгаа нь байгалийн сэргэн ургалтыг дэмжих буюу өсвөр модыг хамгаалах ажлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

